



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/337

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 1 иргэн, 1 аж ахуйн нэгжийн 0.4025га (4025м²) газрын газар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын ...-ны өдрийн А/357 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын талбайн хэмжээ (м ²)	Газрын байршил	Газрын зориулалт	Газар эзэмших хугацаа	Хучингуй болгож буй шийдвэрийн огноо
1	Өлүшкин овгийн Чадраабал Барсболд (РЭ79041610)	(210700181 хуучин нэгж талбарын дугаар)	111	5-р баг Зах	Худалдаа, нийтийн үйлчилгээ	40	Аймгийн Засаг даргын 2010.04.02-ны өдрийн А/113 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийн 7 дахь заалт
2	"Монгол фармерс маркет" ХХК (РД.6044689)	6712008739	3914	8-р баг Согоот-2 210 тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээ	40	Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/350 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь хэсгийн 8 дахь заалт

Нийт талбайн хэмжээ-4025м²

[Signature]

-----000-----